

МОНГОЛЫН ТӨРИЙН ТУСГААР ТОГТНОЛЫН СЭРГЭЛТ, БЭХЖИЛ, ХӨГЖЛИЙГ ШИНЖСЭН БҮТЭЭЛ

*С.Дамдинсүрэн**

Аугаа суут Чингис хааны нэгтгэн байгуулсан Их Монгол Улсын 800 жилийн ойн он - 2006 он Монголын ард түмний бахархал болсон тэмдэглэлт үйл явдлаар дүүрэн байлаа. Их ойн баярын жил өндөрлөж буй энэ өдрүүдэд Монголын тусгаар тогтнолыг сэргээн тунхагласаны 95 жилийн ой тохиож баяр дээр баяр нэмэв. 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр монголчууд манжийн ноёрхлыг эцэс болгож, Их эзэн Чингис хааныхаа өвлүүлэн үлдээсэн төрийн тусгаар тогтнолоо сэргээж, олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсаа дэлхий дахинаа зарлан тунхагласан билээ. Төрийн тусгаар тогтнол бол монголчууд үндэстний хувьд бүрэлдэн нэгдэж нягтрах, дархлагдан орших, дэвжин хөгжих үнэт зүйл мөнийг өнгөрсөн түүхээсээ гүнээ ухаарч түүнийгээ нандигнан хамгаалж, төр ёсоо хэрхэн дээдлэж ирснийг ХХ зууны түүх тод томруун харуулж байна.

Нэрт түүхч, шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, доктор, профессор Л.Жамсрангийн туурвисан “Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт” нэгэн сэдэвт бүтээл Монгол Улсын тусгаар тогтнолыг сэргээж, хамгаалж, бэхжүүлэхийн төлөө Монголын ард түмний тэмцэл, бүтээн байгуулалтын баялаг туршлагыг нээн харуулж нэгтгэн дүгнэхэд зориулагджээ. ХХ зууны эхний хагасыг хамарч буй энэ бүтээл тусгаар тогтнолын асуудлыг нийт Монгол үндэстний хэмжээний өргөн агуулгаар тавьж цаг, үе, нөхцөл байдал, дотоод, гадаад эерэг, сөрөг хүчин зүйлсийг нягтлан тунгаасан бүтээлч санаа дүгнэлтээр баялаг юм.

Энэхүү бүтээл: 1900-1919 он; 1920-1930 он; 1931-1949 он гэж он дарааллаар заагласан гурван бүлэг, 19 зүйл, удиртгал, дүгнэлт гэсэн бүтэцтэй, 305 хуудастай бөгөөд уг асуудлыг манай түүх судлалд анх удаа цогцолбороор авч үзсэнээр онцлог ажил болжээ.

Тусгаар тогтнолын сэргэлтийг ихэвчлэн олон улсын харилцааны буюу гадаад хүчин зүйлийн талаас авч үздэг ерөөсгөл хандлагыг шүүмжлэж Монголын тусгаар тогтнол бол Монгол орны амьдрал, монголын ард түмний язгуур эрх ашиг, тэдний эх оронч шаргуу тэмцэл, хөдөлмөрийн үр дүн мөнийг дүгнэн харуулахыг зохиогч онцлон анхаарсан байна. Уг бүтээлд 1911 оны Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний ялалтыг “үндэсний эрх чөлөөний хувьсгал” гэж нэрлэх, улсын нэрийг олноо өргөгдсөн Монгол Улс гэж нэрлэх нь зохистой гэсэн санал дүгнэлтээ дахин нотолжээ. Гэхдээ энэ нь нийт

* С.Дамдинсүрэн – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өргөн цар хүрээ, мөн чанар, агуулгыг бүрэн тусгасан нь хараахан бус буй заа. Шинэ тулгар тогтсон Монгол Улсын засгийн газар бодлогоо бүх монгол угсаатанд ойлгуулах, Чин улсын захиргаанд байсан бүх нутгаа чөлөөлөх, юуны түрүүнд Ар, Өвөр ба Барга, Хөх нуур, Алаша, Или Тарбагатайн монголчуудын бүх нутгийг хяналтандаа авах улмаар Хятадын өмнөт нутагт бүгд найрамдах засгийн газар ба бусад олон улсаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх зэрэг нийт монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өргөн агуулгыг тусгасан зорилтыг дэвшүүлсэн тухай зохиогч маш чухал дүгнэлт хийсэн байна.

1911 онд өрнөсөн Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн 1912 онд дууссан гэх ташаа үзэл, түүний зөвхөн Манжийн ноёрхолын эсрэг тэмцлээр хязгаарлаад Дундаг иргэн улсын дээрэнгүй бодлогыг эсэргүүцсэн шинж, чиглэлийг нь бүрхэгдүүлдэг зэрэг манай түүх судлалд оршсоор ирсэн дутагдлыг зохиогч шүүмжлэн няцаахын хамт империалист гүрнүүд түрэмгий зорилтын үүднээс Монголыг нөлөөнийхээ хүрээнд хэрхэн хуваарилж таслан хуваасныг илчлэн харуулсан нь их ач холбогдолтой юм.

Их хүрээнд Монголын тусгаар тогтнолыг зарлан тунхагласан явдал Манжийн ноёрхолд байсан Монголчуудын үндэсний эрх чөлөөний тэмцлийг зоригжуулан, Монгол Улстай нэгдэх гэсэн хөдөлгөөн Өвөр Монголын 49 хошууны 35, Цахар 8 хошуу, Хөлөнбуйрын Баргын хошуудыг хамран өрнөж, Монгол улстай нэгэн улс болон нэгдэх саналаа илэрхийлсэн албан батлан бичиг гаргаж тус тусын төлөөлөгчидөө ирүүлж байсан тухай, тэдгээрийг Живзундамба хутагт талархан хүлээн авч эл хэрэгт гавьяа байгуулсан хүмүүсийн зэрэг дэвийг ахиулах, шан харамж олгох зэргээр хөхиүлэн, бичиг, цэргийн чадвартай зарим ноёд, түшмэдийг Монгол Улсын Ерөнхийлөн Захирах Яам болон төрийн бусад яаманд дэвшүүлэн ажиллуулсан тухай олон баримтыг нэгтгэн судалснаараа зохиогч 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн зорилго, агуулга, хүрээгээрээ бүх монголчуудын язгуур эрх ашгийг илэрхийлсэн нийт үндэстний үйл хэрэг мөнийг нотлон харуулсанд энэ бүтээлийн бууршгүй үнэ цэнэ оршиж байна.

Манжийн ноёрхолыг устгаж Монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээн тунхагласан Монголын ард түмний тэмцэл Ар, Өвөр Монголыг нэгтгэх, Монгол үндэстний нэгдмэл улсыг байгуулах, ДИУ-ын эзлэн түрэмгийлэх бодлогыг эсэргүүцэх шинэ шатандаа шилжсэн хэмээх дүгнэлт хийсэн, мөн Хятад, Орос хоёр өөрсдийн явцуу сонирхол түрэмгий санаархлаар үгсэн хуйвалдаж Монголын тусгаар тогтнолыг хэрхэн Хятадын эзэн эрхийн дор автономит эрхтэй болгосныг дотоод гадаад нөхцөл байдал, хүчин зүйлтэй холбон нарийвчлан судалж түүхийн үнэн

бодит баримтад тулгуурлан дэлгэрэнгүй тайлбарлан гаргасан үнэлэлт дүгнэлтүүд зохиолын томоохон хэсгийг бүрэлдүүлж байна.

Энэ зохиолд: Монгол Улсын Засгийн газар дипломат аргаар зорьсноо гүйцэтгэхээр найдлага тавих болсон нь монголчууд үндэсний нэгдэл, төрийн тусгаар тогтнолынхоо төлөө хийсэн тэмцлийн гурав дахь шат мөн гэсэн бас нэгэн шинэлэг санаа дэвшүүлсэнээ тухайн үед гаргаж байсан тунхаг, суртал ухуулга, уриалах бичгүүд, Орос, Хятад, Монголын гурван этгээдийн бага хурал зэрэг олон хэлбэрийн баялаг сурвалж материалаар нотлон харуулжээ. Орос, Хятад, Монгол гурван этгээдийн 1914-1915 оныг дамнан хуралдсан Хиагтын бага хурлын талаар хийсэн шинжилгээ судалгаа нь Орос, Хятадаас Монголын талаар баримталсан байр суурь, бодлогын хуваан захирах түрэмгий шинжийг илчлэн, Монголын төлөөлөгчдөөс хэрхэн хоёр их гүрний шахалтын эсрэг тусгаар тогтнолынхоо төлөө цуцашгүй шаргуу тэмцсэн тууштай, эх оронч уламжлалыг өргөнөөр тусгасан нь танин мэдэхүй хийгээд арга зүйн хувьд ихээхэн үнэ цэнэтэй юм. Энд Хятадын сюзеренитетийн болон Монголын автономитын учир утга, мөн чанарыг хэрхэн ойлгож тайлбарлаж байсныг бага хурлын протокол, баримтад тулгуурлан гүн гүнзгий тал бүрээр шинжилж тэдгээрийг нэр томъёоны төдийгүй, тус тусын эрх зүйн хэм хэмжээ, аль алиных нь хязгаарлал, хамаарлыг тодорхойлсон шинэлэг санаа дэвшүүлэхийн хамт, Хиагтын гурван этгээдийн хэлэлцээр бол ДИУ Монголын тусгаар тогтнолыг цуцалж бутарган захирах эрхийн үндэс болов гэсэн дүгнэлт хийсэн ажээ. Энэ дүгнэлт нь уг хэлэлцээрийн түүхэн үүрэгт өгөх үнэлгээний нэг л тал - Хятадын сюзеренитетэд холбогдох тул түүний бусад талыг цогцоор нь хамруулан хураангуйлан нэгтгэсэн үнэлгээ үгүйлэгдэх талтай. Хиагтын бага хуралд Монголын төлөөлөгчид 9 сарын турш тусгаар тогтнолоо тууштай хамгаалан тэмцсэний үр дүнд түүнийг эвлэн цуцлах оролдлогыг няцааж чадсаны ач холбогдол, үр дагаварыг улам гүнзгийрүүлэн судлах шаардлагатай нь тодорхой юм.

Хиагтын гурван этгээдийн Гэрээнд гарын үсэг зурсаны дараахнаас Хятад нь Ар Монголын автономийг устгаж өөртөө нэгтгэх явуулгыг зугуухан хийсээр 1919 онд түрэмгий санаархлаа хэрхэн гүйцэлдүүлсэн, түүнийг ДИУ-ын ерөнхийлөгч зарлигаар баталгаажуулсан зэрэг нь монголын ард түмний тэмцлийг дахин өрнөхөд хүргэсэн, барон Унгерний хүчийг ашиглаж автономийг сэргээснийг “төрийн тусгаар тогтнолын төлөө хийсэн нэг том алхам, монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хоёр дахь үеийн төгсгөлийн нэн чухал үр дүн мөн” гэж үнэлжээ. Тэр үеийн тэмцэл цаг хугацаа хэлбэр далайцаараа Монгол нутгийн янз бүрийн хэсэгт алаг цоог, уван цуван гарч байсан боловч зохиогчийн дүгнэснээр “цөм л монгол угсаатны үеийн үед уламжилж ирсэн нэгдсэн Их Монгол Улсаа сэргээх

мөрөөдлийг шарын шашны тугийн доор Ар Монголоор төв болгон хэрэгжүүлэх зорилготой байжээ”.

Монголчуудын эрх чөлөөний тэмцлийн шинэ өрнөлтийн үед үндэсний ардчилсан хувьсгал ялж Ардын эрхт шинэ Монгол Улсыг байгуулахдаа Зөвлөлт Орос Улс ба олон улсын коммунист хөдөлгөөнийг түшиглэсэн бөгөөд төрийн тусгаар тогтнолоо бататгаж бэхжүүлэхийн төлөө тэмцэхдээ Зөвлөлт Орос Улсыг түшиж бусад олон улсаар дэмжүүлэх гадаад бодлогыг үндсэн чиглэлээ болгосон гэж үзсэн байна. Энэ нь олноо өргөгдсөн Монгол Улсын гадаад бодлогын чиглэлийг шинэ нөхцөлд шинэ агуулгаар залгамжилсан гэж дүгнэжээ. Энэ үеийн Монголын тусгаар тогтнолын анхны алхмууд, Монгол, Хятадын харилцааг зохицуулах талаар Зөвлөлт Оросын зуучлал, 1924 оны Зөвлөлт, Хятадын хэлэлцээр түүний мөн чанар, зорилт, БНМАУ-ын эдийн засгийн тусгаар тогтнолоо хангахын төлөө явуулсан бодлого үйл ажиллагаа, Монголын улс төр олон нийтийн байгууллагуудаас Хятадын хувьсгалт нэгдмэл фронттой холбоо тогтоож ажилласан Хятадын үндэсний нутгуудын эрх чөлөөний тэмцлийг дэмжих зэргээр тусгаар тогтносон төр улсаа бэхжүүлэх дотоод, гадаад таатай нөхцөл бүрэлдүүлэх чиглэлээр явуулсан бодлого, үйл ажиллагаа, Зөвлөлт Холбоот Улстай тогтоосон хамтын ажиллагааны цар хүрээ, түүнийг Монгол Улсын хөгжлийн чухал хүчин зүйл болгосон гэрээ, хэлэлцээр, бүтээн байгуулалтын ололтуудыг харилцан нөлөөлөл, хөгжил хөдөлгөөнд нь эерэг сөрөг үр дагавартай нь авч үзсэн бүтээлч үнэлэлт дүгнэлтүүд, түүхэн үнэнийг сэргээсэн баялаг мэдээлэл нь манай түүх судлалд үнэтэй хувь нэмэр болсныг онцлон тэмдэглэж байна.

1920-30-аад оны үеийн Монгол, Орос, Хятадын харилцааны гол хандлага нь дэлхийн хувьсгалын үзэл санааны тугийн дор эерэг энергийг олж байсан тэр онцлог ч энэхүү бүтээлд зохих тусгалаа олжээ.

1930-аад оны эхнээс БНМАУ империалист, милитарист хүчний түрэмгийлэлийн аюулын эсрэг тусгаар тогтнолоо хамгаалан бэхжүүлэхийн төлөө хийсэн тэмцэл, цэрэг стратегийн хүрээнд явуулсан үйл ажиллагааг судлан шинжилсэн хэсэг тус зохиолын тодорхой байрыг эзэлжээ. Японы империалист хүчний түрэмгийлэлийн үед Монгол, Орос, Хятадын харилцааны хүчин зүйлийг Монголын тусгаар тогтнолын эрх ашигт нийлүүлсэн эергээр хөгжүүлж, фашизм дайн түрэмгийлэлийн эсрэг бүх нийтийн үйлст хувь нэмэрээ оруулсан зэрэг нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэхэд болон их гүрнүүдийн зүгээс Монголын тусгаар тогтнолд хүндэтгэлтэй хандахад нааштайгаар нөлөөлсөн онцлог үйл явдлуудыг зохиолд дэлгэрэнгүй авч үзсэн байна. ЗХУ, түүний удирдагч И.В.Сталинаас Монголын статус-кво-г хүлээн зөвшөөрүүлэхээр холбоотон гүрнүүдийн удирдагч нартай тохиролцсон учир шалтгаан, ач холбогдлыг Алс дорнодод дайны голомтыг арилгаж аюулгүй, энх тайван

тогтвортой байдлыг тогтоох стратегийн нийтлэг зорилттой холбож тавьснаар үр дүнд хүргэж чадсаныг болон Монгол, Хятадын харилцаанд зуучлагч үүргээ хэрхэн гүнзгийрүүлэн хэрэгжүүлснийг 1945 оны зун Москвад ЗХУ, Хятадын засгийн газрын хооронд сар гаруй хугацаанд үргэлжилсэн хэлэлцээрийн үеэр Ар Монголын тусгаар тогтнолыг ДИУ-аар зөвшөөрүүлэхийн тулд дипломатын нарийн ээдрээтэй арга тактик, тууштай байр суурь, бодлого баримтлан Хятадын нутгийг Японы эзлэлтээс чөлөөлөх асуудалтай холбон тавьсны эцэст амжилтанд хэрхэн хүрснийг удаа дараагийн уулзалт, хуралдааны протокол баримт бичигт хийсэн шинжилгээгээр нотлон харуулсан байна. 1946 оны эхээр БНХАУ БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн хийгээд, 1949 онд БНМАУ түүнээс дипломат харилцаагаа тасалж БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосноор Монголыг Хятадын дэвсгэр нутгийн нэг хэсэг хэмээх үзэл ямар хуурмаг хэврэг зүйл болохыг нотолж 1911 онд эхлэл нь тавигдсан Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт ямаршуу ээдрээтэй бэрх замыг туулж шинэ шинэ ололт амжилтаар баталгаажиж БНМАУ бодитой оршиж холбоотон их гүрнүүдийн хүндэтгэлийг олж, хөрш хоёр их гүрнээрээ хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн бие даасан субъектын хувьд бие даасан түүхэн үүрэг гүйцэтгэх болсныг эрдэмтэн доктор Л.Жамсран монгол, орос, хятад хэлний арвин их сурвалжууд, эдгээр болон япон, англи хэл дээр гарсан олон ном зохиолууд архивын үлэмж материалыг бүтээлчээр ашиглан боловсруулж нэгтгэн дүгнэнээрээ Монголын түүхийн шинжлэх ухааны хөгжилд үнэ цэнэтэй шинэлэг бүтээл тууригдсан байна. Энэ бүтээлийн бас нэг ололт бол түүхийг зээнгүйдүүлдэг түүх судлал дахь урьдын дутагдлыг арилгах чухал алхам хийж Монголын тусгаар тогтнолын төлөө мятрашгүй тэмцэж төр улсаа сэргээн мандуулах үйлст мөнхөд дурсагдах олон эх орончдын алдрыг сэргээсэнд оршно.

Монгол үндэстний нэгдлийн үзэл санаа нэвтэрхий энэ бүтээл эх түүхээ эрхэмлэдэг эх оронч сэтгэлтэй Монгол хүн бүрийн сонорт хүрэх болтугай. Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн доктор, профессор Л.Жамсрангийн нэлээд ховордсон энэхүү бүтээлийг дахин хэвлэж нийтэд хүртээмжтэй болгоосой.